

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Огноо: 2019.06.04

**БАЯНХОНГОР СУМЫН 12 ДУГААР БАЙРНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: Баянхонгор сумын 12 дугаар байрны дээврийн
засварын ажил:
БХАОНӨГ/201933

2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баянхонгор сумын 12 дугаар байрны дээврийн засварын ажил БХАОНӨГ/201933-ыг** гүйцэтгэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.meps.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 / тавин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг ТЭЗҮ-д хавсаргасан болно.

Үнийн саналыг [**2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11 цаг**]-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [**2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн [11цаг 10 минут]**]-д аймгийн Орон нутгийн өмчийн газрын 116 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцоно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар
(нэг давхарын 116 тоот өрөө, Орон нутгийн өмчийн газрын
мэргэжилтэн С.Рэнцэнбямбаас авах буюу, 70443224
88295091 утасаар холбогдоно.)**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.
Үүнд: **[БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтийн ажил. БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил]**
 - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: **Энэ ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх машин, тоног төхөөрөмжийн жагсаалт, өөрийн эзэмшлийн болон түрээсээр эзэмшихийг нотлох баримтын хамт ирүүлэх.**
2. Тендерийн иж бүрдэл
 - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл, түүний гэрээ, тэдгээрийг баталуулсан хуулбар;
 - (д) Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заагдсан шаардлагатай бусад материалыг ирүүлэх.
3. Тендерийн үнэ
 - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болох ба энэ нь тодорхой үнэдслэлтэй байна.
 - 3.3. Тендерт оролцогч нь тухайн ажлын зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарь, ажлын тоо хэмжээнд хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 45 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нэгж болон нийт үнэд багтаасан байна.
4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 5. Алдааг залруулах**
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь бэлтгэж ирүүлэх үнийн санал, төсвийн тооцоондоо ажлын зураг төсвийн үнэ-1.000.000 төгрөг, бусад холбогдох зардлын тооцоог ЗТБХБ-ын сайдын 2012 оны 1 сарын 13-ны 18 тоот, 2012 оны 181-р тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу төсвийг тооцсон байна. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэн ирүүлэх ба бусад холбогдох хууль, журмын дагуу тооцогдох татвар хураамжуудыг тооцон, дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ:</p> <p>Үүнд: 1. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтийн ажил. -БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил] /Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна. /</p> <p>2. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан, Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>3. Сүүлийн [2017, 2018 оны] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>4. ТББ-т хавсаргасан жишиг маягтаар гаргасан үнийн санал;</p> <p>5. Ажил гүйцэтгэх график ирүүлэх</p> <p>6. Улсын бүртгэлийн гэрчилгээний наториатаар баталуулсан хуулбар</p> <p>7. Харилцагч болон арилжааны бүх банкуудын тодорхойлолт. /Монгол банк байж болно/</p> <p>8. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>9. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Удирдах болон инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлнэ. Нийгмийн даатгалын 2019 оны эхний улирлын байдлаарх баталгаажсан НД-7, НД-8 маягыг ирүүлнэ.</p> <p>10. Шүүхийн болон ШШГ байгууллагуудын хүчинтэй тодохойлолт</p> <p>11. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан нийт төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</p> <p>12. Сүүлийн 2 жил буюу зөвхөн 2017, 2018 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан нийт төсөвт өртгийн үнийн дүнгийн 60 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй барилга угсралтын ажлын гэрээ байгуулж ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна. Ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолт эсвэл захиалагчийн дүгнэлтийг ирүүлнэ.</p> <p>14. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн</p>

	<p>хэмжээ: Батлагдсан нийт төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.</p> <p>- Байгууллагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлоор /Хувь хүний нэр дээрх буюу захирлын нэр дээрх дансны үлдэгдлийг тооцохгүй/</p> <p>-Арилжааны банкны зээлийн тодорхойлолтыг тус тус тооцно /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой эсхүл шаардлагатай баримт материалыг үндэслэн гэх тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй судлагдсан тодорхойлолт байх/</p> <p>15.Энэ ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх машин, тоног төхөөрөмжийн жагсаалт, өөрийн эзэмшлийн болон түрээсээр эзэмшихийг нотлох баримтын хамт ирүүлэх.</p> <p>16. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>Жич:Санхүүжилтийн эх үүсвэр нь: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр: /Нийт төсөвт өртөг нь 45.0 сая төгрөг/ 2019 онд батлагдсан төсөвт 40.019.800 (дөчин сая арван есөн мянга найман зуун) төгрөг. 2019 онд санхүүжигдэх нь: 40.019.8 төгрөг</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаас хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Огноо: 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Давхар болон өрөөний дугаар: [Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нэг давхарын 116 тоот өрөө. Огноо: 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Цаг: [11 цаг 10 минут]</p>

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй. |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|---|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь¹**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч хэвлэгдэх товхимолд тавигдах техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг бүрэн хангаж, хэвлэх ажлын явцад гарсан алдаа зөрчлийг бүрэн хэмжээгээр арилгасан байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
 - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (е) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Баянхонгор сумын 12 дугаар байрны дээврийн засварын ажил:
БХАОНӨГ/201933
- 2.1 **Ажил нь:** Баянхонгор сумын 12 дугаар байрны дээврийн засварын ажил *түүнтэй холбогдох ажлын зураг, хавсралтуудаас бүрдэнэ.*
- 3.1 Төслийн менежерийг захиалагч томилно.
- 4.1 Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулагдсан өдрөөс.

- Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэж аймгийн ЗДТГ-с томилсон комисст хүлээлгэн өгсөн байх.
- 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 9.1** Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
- 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
- 17.1** Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2019 оны 07 дугаар сарын 15 -ны дотор гаргаж өгнө.
Гүйцэтгэлийн зургийг 2019 оны 07 дугаар сарын 15-ны дотор гаргаж өгнө.
Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ **100.000 төгрөг** байна.
- 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0-иар тооцно.

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/,Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд хийхээр тооцоологдсон байгаа тул БН ба Д-ийн зохих заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэсэн байна.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Уг барилга нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 12 дугаар байрны дээврийн засварын ажил.

Дээврийн ажил: Хуйлмал материалан дээвэр буулгах. Уг барилга нь хавтгай дээвэртэй байх ба 30мм зузаан цементэн тэгшилгээ хийж 1 үе наамал уур тусгаарлагч хийх. Тортой хөөсөнцөрөөр хучилт дулаалах, налуулга гаргах. Налуу дээврийг 3 үе шилэн рубериод буюу 2 үе прегаминаар бүрж хар тосон шаваасан дээр хамгаалалтын том ширхэгтэй хайргархаг хар цаасан үетэй хийх.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Зургаа. ЗУРАГ

Зургийн санамж

Фото зургийг tender.gov.mn цахим системийн ТЭЗҮ-д т хавсаргав. Тендерт оролцогчид нь зургийн дагуух байршилыг газар дээр нь үзэж, фото зургаар баримтжуулсан товч тайланг гаргаж үнийн саналд хавсарган ирүүлнэ.

Долоо. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарийг: Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаарлагатай бөгөөд үүнийг гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээ ба гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэнэ.

Найм. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [45] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :

Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3 Үнийн санал
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт;
- 5.7 Зураг;
- 5.8 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9 Санхүүжилтийн хуваарь;
- 5.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]